

АЛБАН ХААГЧДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газар нь Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэс болон Эрүүгийн цагдаагийн III хэлтэстэй хамтран 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдөр “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” талаар сургалт зохион байгуулж хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал болон хууль эрх зүйн орчин, уг гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл авсан. Түүнчлэн мөн өдөр тус газрын Ёс зүйн хорооноос “Төрийн албан хаагчийн ёс зүй” талаар хичээл орж ёс зүйн хорооны чиг үүрэг, зөрчлийн харьяалал, гомдол мэдээллийг шалгаж зөрчлийг шийдвэрлэх талаар мэдээлэл хүргэлээ.



Харин 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албаны эрдэм шинжилгээний ажилтан, хоол зүйн ухааны доктор Ж.Баясгалан “Зөв зохистой хооллолт” сэдвээр тус газрын албан хаагчдад хичээл орж хоногт авах хоолны илчлэг болон хязгаартай хэрэглэх хоол хүнс, буруу хооллолтоос зөв зохистой хооллолтонд шилжих талаар ярилцлаа. Үүнээс гадна мөн өдөр ГИХГ-ын архивч-оператор Ч.Баасанжав “Баримт бичгийн стандарт”, “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй” сэдвийн хүргээнд хичээл орж албан хаагчид баримт бичиг боловсруулах болон цаасан суурьт баримтад техник боловсруулалт хийхэд анхаарах зүйлс, тусгай төрлийн баримтыг ангилан төрөлжүүлэх, хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүйн талаарх мэдлэгээ бататгалаа.

